

2026 он 4 сар 28 өдөр

№ 26/08

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*ТУЗ-ийн гишүүдийн жилийн урамшуулал олгох тухай*

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.6 дахь заалт, Ард Санхүүгийн Нэгдэл ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрэм, Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн дэргэдэх Цалин, Урамшууллын бодлого, ТУЗ-ийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. ТУЗ-ийн гишүүдийн ирц болон өөрийгөө үнэлэх үнэлгээнд үндэслэн тооцсон 2025 оны урамшууллыг нэгдүгээр хавсралтын дагуу **ОЛГОСУГАЙ.**
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Энхзулд, Санхүү эрхэлсэн захирал Г.Билгүүнд, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитор М.Мөнх-Эрдэнэ нарт тус тус **ДААЛГАСУГАЙ.**

ДАРГА



Ч.ГАНХУЯГ

2026 он 4 сар 28 өдөр

№ 26/09

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*2025 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан  
санхүүгийн тайланд дүгнэлт гаргах тухай*

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, Ард Санхүүгийн Нэгдэл ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрэм, Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн дэргэдэх Аудитын хорооны зөвлөмж, ТУЗ-ийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Нексия Глобал Монголиа Аудит ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд гаргасан аудитын дүгнэлтийг хүлээн авч, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх “Хангалттай” гэж дүгнэснийг **БАТАЛСУГАЙ.**
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, компанийн 2025 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар танилцуулж, батлуулахыг Дотоод аудитор М.Мөнх-Эрдэнэд **ДААЛГАСУГАЙ.**

ДАРГА



Ч.ГАНХУЯГ